

ЭШОПБХурал зохион байгуулагчид:



Судалгаа
хөгжлийн
эрдмийн академи



Дархан нутаг ТББ

Мэдээллийн хамтрагч:

dt darkhantimes.com

“ДАРХАН ХОТЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ II” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ

Дархан-Уул аймаг, 2015 он

“ДАРХАН ХОТЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ II” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Дархан-Уул аймгийн эрдэмтэд, багш нарын үүсгэн байгуулсан “Судалгаа хөгжлийн эрдмийн академи”, Ардчилсан нам хамтран “ДАРХАН ХОТЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ II ”сэдэвт Эрдэм Шинжилгээ, Онол Практикийн бага хурлыг эрдэмтэд, судлаачид, их дээд сургуулийн багш нар, төрийн ба төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд болон олон нийтийн дунд нээлттэй зохион байгуулна.

1. Хурлын зорилго:

Дархан –Уул аймгийн хөгжлийн стратегийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, орон нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэд олон нийтийн санаачлагыг өрнүүлэх, хүний хөгжил, амьдралыг дэмжин тэтгэх, эрхзүйн орчныг бий болгох, тохилог хөгжилтэй Дархан хотыг цогцлоох,

2. Хурал болох газар:

2015 оны 04 сарын 30 –ны өдрийн 10 цагт дараах салбар хуралдааны дэгтэйгээр эхэлнэ. Үүнд:

1. Төр, нийгмийн бодлого: **АШУҮИС-ын соёлын төвд**
2. Хууль эрх зүй: **МСҮТ-ийн Эрдмийн өргөөнд**
3. Үйлдвэрлэл, технологи, дэд бүтэц: **ШУТИС-ийн хурлын зааланд**
4. ХАА, байгаль орчин: **УГТСЭШХ-ийн хурлын танхимд**
5. Эдийн засаг, төсөв санхүү, төсөл хөтөлбөр: **ХААИС-ын номын санд**

3. Илтгэл хүлээж авах:

2015 оны 04 сарын 01 хүртэл хүлээн авч хурлын өмнө илтгэлийн хураангуй хэвлэгдэн гарсан байна. Илтгэлийг polyglot_122@yahoo.com хаягаар хурал зохион байгуулах комисст ирүүлэхээс гадна АШУҮИС-ийн Дархан –Уул аймаг дахь Анагаах Ухааны сургуулийн Эрдэм шинжилгээ гадаад харилцааны албанд хэвлэсэн байдлаар болон файлаар хүргүүлнэ.

4. Шагналын сан:

Салбар хуралдаан тус бүрээр 1, 2, 3 байр, шагналт 3 байр эзлүүлж ивээн тэтгэгч байгууллагуудын шагналаар шагнаж урамшуулна.

I байр:	Батламж, 1.000.000 төгрөг
II байр:	Батламж, 700.000 төгрөг
III байр:	Батламж, 500.000 төгрөг

Тусгай байр:

1. Батламж, ивээн тэтгэгч байгууллагын шагнал
2. Батламж, ивээн тэтгэгч байгууллагын шагнал
3. Батламж, ивээн тэтгэгч байгууллагын шагнал

5. Тавигдах ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Зарлагдсан сэдвийн агуулгад нийцсэн
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаан дээр суурилсан
- Дарханд тулгамдаж буй асуудалтай холбогдсон
- Шинэлэг санаа дэвшүүлсэн
- Гаргасан дүгнэлт бодитой байх
- Үсгийн фонд Times New Roman
- Үсгийн хэмжээ 12pt, мөр хоорондын зай 1,5
- Ишлэл зүүлтийг хуудасны доод талд 10pt
- Хүснэгт, зураг, диаграммыг хар, цагаан, саарал өнгөөр дүрслэнэ
- Хуудасны тоо А4, 4-8 нүүр
- Өгүүлэл нь үндсэн бичвэрээс гадна ном зүй, хураангуйтай байна.
- Илтгэлийн баруун дээд хэсэгт илтгэгчийн овог нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

5. **Эрдэм шинжилгээний илтгэлийн ерөнхий бүтэц:**

1. Илтгэлийн нэр
2. Илтгэлийн хураангуй
3. Түлхүүр үг
4. Илтгэлийн оршил
5. Илтгэлийн үндсэн хэсэг
6. Дүгнэлт

7. **Хуралдааны дэг ба салбар хуралдаан:**

Дараах 5 чиглэлээр салбар хуралдаануудыг зарлаж байна. Удирдамжийг хүргэхэд сэдвийн тоймыг хавсаргана. Үүнд:

1. Төр, нийгмийн бодлого (Эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, нийгмийн хамгаалал)

- Салбар хуралдааны дарга АШУҮИС-ийн Дархан –Уул аймаг дахь Анагаах Ухааны сургуулийн захирал, Анагаах ухааны доктор (Ph.D) Д.Зоригтбаатар
Харилцах утас: 99994690

2. Хууль эрх зүй (хүний эрх, хүчирхийлэл, архидан согтуурахтай тэмцэх, хүүхэд гэр бүл хамгаалал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх)

- Салбар хуралдааны дарга Дархан –Уул аймгийн МСҮТ-ийн захирал, Боловсрол судлалын ухааны доктор (Ph.D) Ч.Лхагвасүрэн
Харилцах утас: 99375265

3. Үйлдвэрлэл, технологи, дэд бүтэц (дэвшилтэт технологи, инновац, шинэ бүтээл)

- Салбар хуралдааны дарга ШУТИС-ийн Дархан –Уул аймаг дахь Технологийн сургуулийн дэд захирал, Техникийн ухааны доктор (Ph.D) Я.Батцэцэг:
Харилцах утас:99375171

4. ХАА, байгаль орчин (экологи, нөхөн сэргээлт, хот төлөвлөлт, хот байуулалт, аялал жуулчлал)

- Салбар хуралдааны дарга Дархан –Уул аймаг дахь УГТСЭШХүрээлэнгийн Ургамлын генетик нөөцийн секторын эрхлэгч, ХАА-н ухааны доктор (Ph.D) Т. Атарсайхан, Харилцах Утас: 99033292

5. Эдийн засаг, төсөв санхүү, төсөл хөтөлбөр (төсвийн хэмнэлт, шилэн данс)

- Салбар хуралдааны дарга Дархан –Уул аймаг дахь ХААИС-ийн багш, Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) Ү. Хадбаатар, Харилцах утас: 99035078

Хаалтын ажиллагаа, шагнал гардуудах ёслол Залуучууд театрт 5 сарын 1- ны 12 цагт болно. Дараа нь хүндэтгэлийн гала тоглолттой.

8. Илтгэх хугацаа:

- Үндсэн илтгэл –8 мин
- Хэлэлцэх хугацаа: 5 мин (асуулт, хариулт)

9. Илтгэгчийн мэдээллийг хүлээн авах асуулт.

1. Илтгэгчийн овог нэр
2. Албан тушаал, ажилдаг газар
3. Эрдмийн зэрэг, цол
4. Илтгэлийн сэдэв
5. Холбоо барих утас, цахим хаяг

10. Нэмэлт мэдээлэл:

Хурлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг **darkhantimes.com** website хаягаар авч болох ба зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) дэд профессор Л.Нарантуяа, Харилцах утас: 99378536, менежер, доктор, (Ph.D) О.Отгонтогоо, Харилцах утас: 94332233 хандан авна уу.

Салбар хуралдааны илтгэлийн сэдвүүдийн чиглэл:

I. Төр, нийгмийн бодлого

1. Дархан-Уул аймгийн Дархан сумыг Дархан хот болгох нь
2. Ухаалаг Дархан хот хөтөлбөр боловсруулах
3. Хөдөлмөр нийгмийн хамгааллыг сайжруулах нь
4. Стандартын шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлэх, хянах, хяналтыг оновчтой оновчтой болгох нь
5. Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, засварлах нь
6. Хотын тохижилтыг сайжруулах нь
7. Ажилтай орлоготой иргэнийг бий болгох нь
8. Дархан хотын иргэний соёлыг төлөвшүүлэх нь
9. Эрдэм боловсролтой, эрүүл чийрэг, эрхэлсэн ажилтай, энэрэнгүй хамгаалалттай, эрхэмсэг иргэнтэй хотыг бий болгох нь
10. Асуудаг, анхаардаг, ажилладаг, авилгагүй, амжилтанд хүрсэн засаглалыг бий болгох нь
11. Гэр хорооллын интернетийн төвүүд, цахим талбай бий болгох
12. Иргэн нь баян Дархан хотыг бий болгох нь
13. Амар тайван Дархан хотыг байгуулах нь
14. Залуучуудад зориулсан чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх цахим ертөнц “Wi Fi” орчинг нэмэгдүүлэх
15. “Хөршийн холбоо-хамгаалалт” иргэдийн оролцоо санаачлагад суурилсан хөтөлбөр
16. Тогтвортой хөгжлийн хот байгуулах нь
17. Иргэд аюулгүй, эрүүл орчинд тайван амьдрах нь
18. Дархан хотын дүрэмтэй болох нь (нийтэд ойлгомжтой, заавал мөрдөх, хялбаршуулсан дүрмийг бүх нийтээр мөрдөх)
19. Хотын өрсөлдөх чадварын судалгааг хийх нь
20. Сүлжээний хүртээмж, чанарыг сайжруулж, утасгүй интернет бүхий хот болгох судалгааг хийх
21. Иргэд эмчээ сонгон үйлчлүүлэх нь
22. Цахим-эрүүл мэндийг сайжруулах нь
23. Эмчилгээ, оношлогооны орчин үеийн шинэ техник, технологийг нэвтрүүлэх нь
24. Архи тамхины хэрэглээг судлах нь
25. Хөдөлгөөний хомсдолыг судлах ба чийрэгжүүлэлтийг эрчимжүүлэх нь
26. Эрүүл бус хүнсний хэрэглээг бууруулах нь
27. Рашаан сувилалыг хөгжүүлэх нь
28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хот болгох нь
29. Буруу зуршилгүй иргэн хүн төлөвшүүлэх нь
30. Барилгын ослыг бууруулах судалгаа
31. Эрүүл мэндийн үйлчилгээ даатгалын дэлхийн жишигт нийцүүлэх нь
32. Эрүүл ахуйн стандартын хяналт шаардлагыг хангах нь
33. Бүсийн оношлогоо эмчилгээний төв байгуулах боломж
34. Өрхийн эмнэлгүүдийгтоног төхөөрөмж боловсон хүчнээр дэмжих
35. Ядуу өрхийн хүнсний хангамжийн асуудлыг шийдвэрлэх
36. Малчид, оюутан, ажилгүй иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах
37. Багш хөгжлийн төвөөр чадварлаг багштай нарыг бэлтгэх боломж
38. Эмч сувилагч нарын харьцааг 1:3 болгох нь

39. Ардын уламжлалт урлаг соёлыг судлах нь
40. Бүх нийтэд экологийн боловсрол олгох нь
41. Зайны сургалтын хөтөлбөр
42. Сонгодог урлаг соёлыг судлах нь
43. Иргэдийн хог хаях хэв маягт өөрчлөлт орсон эсэхийг судлах нь
44. “Оюутны хөгжлийн төв” байгуулах нь
45. Оюунлаг Дархан хотыг бий болгох суурь судалгааг хийх нь
46. Оюутны хотхон - оюутны нийтийн байр барих төсөл хэрэгжүүлэх нь
47. “Хөдөлгөөнт номын сан” хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх нь
48. Олон нийтийн газар биеэ зөв авч явах хэм хэмжээ, зан заншил, ёс зүйг хэвшүүлэх судалгаа
49. Үйлчилгээний соёлын сургалт, түүний стандартыг боловсруулах нь
50. Дэлхийд тэргүүлэх их дээд сургуулийн салбарыг нээх нь
51. Үндэсний өв соёл, түүх ёс заншлыг тэгш хүндэтгэн, өвлүүлэн хөгжүүлэх нь
52. Хэвлэлийн эрх чөлөө Дархан –Уул аймагт
53. Шашин шүтэх эрх чөлөө Дархан –Уул аймагт
54. Цэцэрлэгийн насны бүх хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах (зуны, нүүдлийн, гэр)
55. Сургууль завсардалтыг бууруулах (төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх)
56. Номын санг цахимжуулах (дигитал номын сан)
57. Сургууль цэцэрлэгийн цогцолбор байгуулах
58. Бүр шатны боловсролын байгууллагад цахим хичээлийг боловсронгуй болгох
59. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв байгуулах асуудлаар
60. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх асуудалд
61. Үндэсний бичиг үсгийг түгээн дэлгэрүүлэх нь
62. Дарханы түүхийн болон байгалийн дурсгалт зүйлсийг хадгалах, хамгаалах
63. Хүүхэд хамгааллын талаар авах арга хэмжээг боловсронгуй болгох
64. Ардын авъяастныг дэмжих
65. Дархан-Уул аймагт оюуны самр байгуулах боломж
66. Монгол зан заншлийн өргөө байгуулах асуудал
67. Урлагийн бүрэн дунд сургууль байгуулах боломж
68. Аймгийн төв номын санг байгуулах үндэслэл, зайлшгүй байдал
69. Спортын бүрэн дунд сургуулийг байгуулах боломж
70. Дархан их сургууль байгуулах нь
71. Иргэдэд үйлчлэх үйлчилгээнүүдийн жагсаалт гаргах, боловсронгуй болгох

II. Хууль эрх зүй

1. Ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх
2. Хүний эрх эрх чөлөөг дээдлэх асуудалд
3. Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээ
4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
5. Шинэ төрлийн гэмт хэрэг тэдгээрийн илрүүлэлт
6. Авто зам – ослоос урьдчилан сэргийлэх нь
7. Архидан согтуурах явдалтай тэмцэх
8. Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

III. Үйлдвэрлэл, технологи, дэд бүтэц

1. Дархан-Уул аймагт үндэсний үйлдвэрлэлийг дэмжих боломж
2. Малын генетик нөөцийг хамгаалах асуудалд
3. Биотехнологийн ололтыг нэвтрүүлэх
4. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, өрхийн аж ахуйг дэмжих, ажилгүйдлийг бууруулах нь
6. Гэр хорооллын төлөвлөлт инженерийн шугам нөхцөлийг сайжруулах нь
7. Инженерийн шийдэлтэй ногоон хотыг байгуулах нь
8. Дархан хотоо шинэ төлөвлөлтөөр хөгжүүлэх нь
9. Эрчим хүчний олон хувилбарт эх үүсвэртэй, агаар нь цэвэр хот болох нь
10. Гэр хорооллын айл бүрийг цэвэр ус, дулаанаар хангах асуудалд
11. Цахилгаан, дулаан, сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлыг судлах нь
12. Барилгын материалын үйлдвэрийг сэргээх нь
13. Зах зээлд өрсөлдөх чадвартай, өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг цогцолбороор нь хөгжүүлэх
14. Байгаль орчинд хөнөөлгүй технологи нэвтрүүлэх нь
15. ДУА-т нефтийн үйлдвэр байгуулах боломж түүний ирээдүйг судлах нь
16. Шарын голын уурхайг далд хэлбэрт шилжүүлж, олборлолтыг нэмэгдүүлэх нь
17. Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хосолсон загвар аж ахуйг бий болгох
18. Сүүгээр анхан шатны боловсруулалт хийх төвүүдийг дэмжих
19. Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх асуудлыг үр өгөөжтэй болгох
20. Дулаан цахилгааны эрчим хүчээр найдвартай хангах
21. СӨХ-ийн оновчтой бүтцийг дэвшүүлэх
22. Дархан хотын BRAND-ыг боловсруулах нь (хотын ерөнхий өнгө, хэлбэр, гудамж талбайн тоноглол, барилга байгууламж, төрийн үйлчилгээ, хувцаслалт, өнгө дизайныг өөрчлөх нь)
23. Цаасгүй технологийг бий болгох нь
24. Өрхийн үйлдвэрлэл, бизнесийг дэмжих
25. Үйлдвэрлэл технологийн парк байгуулах нь зайлшгүй болох
26. Хотыг цахимжуулах, төвлөрүүлэх, хялбаршуулах нь
27. Мэдээллийн дүн шинжилгээнд тулгуурласан урьдчилсан тааварлах системийг бүрдүүлэх нь (Big data цуглуулах)

IV. ХАА, байгаль орчин

1. Газар тариалангийн тулгамдсан асуудлууд
2. Малын удмын сан
3. Ургамлын био технологи
4. Монгол орны газар тариалангийн хөрс, түүнийг бордох асуудалд
5. Хамгаалагдсан хөрсний аж ахуй
6. Өвлийн хүлэмж, түүнийг ашиглах болмжууд
7. Үр тарианы селекци, үрийн аж ахуй
8. Ургамлын генетик нөөц, түүнийг ашиглах боломжууд
9. Төмс хүнсний ногооны таримлын шинэ сортууд, тэдгээрийг тариалах технологи
10. Хөрсний элэгдэл доройтол
11. Ойн зурвас байгуулах
12. Жимс, жимсгэний аж ахуй

13. Ургамлын тарималжуулалт, нутагшуулалт
14. Усалгааны газар тариалан
15. Хүрээлэн буй орчны хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх нь
16. Усны эхийг хамгаалах, усруу хог хаягдал, бохир ус хийхэд хатуу хяналтыг бий болгох нь
17. Усны чанарын шинжилгээг орон нутагт тогтмол хийх нь
18. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх нь
19. Хөрсний бохирдолгүй гэр хорооллыг бий болгох асуудлыг судлах нь
20. Хогны асуудлыг бүрэн шийдсэн хоггүй цэвэр хот болох нь
21. Агаарын температурын эрчимтэй дулааралт – цөлжилтийг бууруулах нь
22. Ногоон байгууламж бий болгох нь
23. Мэдээлэлтэй иргэн – орчны судалгааг хийх нь
24. Цэвэр – Дархан хөдөлгөөн
25. Хог, орчны бохирдлын хяналт, арчилгаа, дахин боловсруулалтын үр өгөөжтэй шийдлүүдийг нэвтрүүлэх судалгаа
26. Амьсгалах агаартай, уух устай, аюулгүй амьдрах хот болох нөхцөлийг судлах нь
27. Агаар нь цэвэр – Дархан, асгасан хоггүй Дархан
28. Цөлжилтийг бууруулах, түүнтэй тэмцэх нь
29. Агаарын бохирдлыг бууруулах нь
30. Ургамал хамгаалах нь
31. Аялал жуулчлалын мэдээллийн сантай болох

V. Эдийн засаг, төсөв санхүү, төсөл хөтөлбөр

1. Цалин хөлс, урамшууллыг үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулан тогтоох нь
2. Иргэнээ дэмжсэн эдийн засгийн нөхцлийг бүрдүүлэх нь
3. Зөөлөн дэд бүтэцтэй байх нь
4. Smart city - дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр
5. Үр дүнд суурилсан цалин, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх нь
6. Иргэн бүрийн ажил эрхлэлт, мэдлэг чадварын судалгааг хийх нь
7. Иргэдийн аж амьдралыг судлах ажлыг тогтмол хийх
8. Статистикийн үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг сайжруулах